

БАТЛАВ.  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА  
Г.НАНДИНЖАРГАЛ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2017 ОНЫ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах газар нэгж, албан тушаалтан
<b>Нэг. Шудрага, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авилгын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгыг хангах чиглэлээр</b>				
1	4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	3. ХАСУМ-д хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг оруулдаг болох	2017	ТЗУГ, ЭБАТ
2	4.1.1.2. нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан дэвшүүлэх	6. Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг батлах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэх	2017	Бүх газар, хэлтэс
3	4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах	1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн цахим системтэй холбогдох нөхцөлийг хангах	2017	ТЗУГ
4	4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах, Авилгын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах	2017	ТЗУГ
<b>Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгыг хангах чиглэлээр</b>				

5	4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож бэхжүүлэх	1. Яамны цахим сүлжээнд авилгын эсрэг төлөвлөгөөг байршуулах, санал, сэтгэгдэл хүлээж авах боломжийг бүрдүүлэх	2017	ТЗУГ
6	4.1.2.4. эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	2017	ТЗУГ, ХШУДАГ
<b>Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
7	4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	1. Яамны санхүүгийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх	2017	ТЗУГ, СХ
<b>Зургаа. Авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
8	4.1.6.5. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах	1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх ажлыг эхлүүлэх	2017	Бүх газар, хэлтэс
9		2. Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод болгох ажлыг зохион байгуулах	2017	Бодлогын газрууд, БХЗГ
10		4. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх	2017	ТБГ, ТЗУГ, ХХ
11		Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах	2017	ТБГ
<b>Арав. Шудрага ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авилгын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>				
12	4.1.10.1. авилгын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авилгыг үл тэвчих	4. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлан,	2017	ТЗУГ, бүх газар хэлтэс

	үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх		
<b>Яамны эрхлэх ажлын хүрээнд</b>				
13	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	Хуулиар болон бусад холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрээр зөвшөөрөгдсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулах	2017	ТЗУГ, ЭБАТ
14		Давхар ажил эрхэлж байгаа ажилтны судалгааг гаргах	2017	ТЗУГ, ЭБАТ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
ТЗУГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Г.МӨНГӨНЗУЛ